



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 43

Мандалговь

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дүгээр зүйлийн 5.1 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 19,901,361.63 төгрөгийн балансын үнэтэй 17,247,846.75 төгрөгийн элэгдэл бүхий дизель түлш үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн , Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Т.Гончигдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” -д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 6 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга / О.Бат-Эрдэнэ / -д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

480219100